3. We have disclosed to you the use of all applications or tools using artificial intelligence, including generative artificial intelligence, that are reasonably likely to have a direct or indirect material effect on the financial statements.
4. We have made available to you all minutes of the meetings of shareholders, directors and committees of directors (or summaries of actions of recent meetings for which minutes have not yet been prepared) held through the *1 January 2023* to the most recent meeting held up to the date of this letter.
5. We confirm the completeness of information provided regarding the identification of related parties. We have disclosed to you the identity of the Group and the Company's related

parties and all related party relationships and transactions of which we are aware, including sales, purchases, loans, transfers of assets, liabilities and services, leasing arrangements, guarantees, non-monetary transactions and transactions for no consideration for the period ended, as well as related balances due to or from such parties at the 31 December 2024 end. These transactions have been appropriately accounted for and disclosed in the financial statements.

6. We believe that the methods, significant assumptions and the data we used in making accounting estimates and related disclosures are appropriate and consistently applied to achieve recognition, measurement and disclosure that is in accordance with IFRSs.
7. We have disclosed to you, and the Group and the Company has complied with, all aspects of contractual agreements that could have a material effect on the financial statements in the event of non-compliance, including all covenants, conditions or other requirements of all outstanding debt.
8. From the date of our last management representation letter through the date of this letter we have disclosed to you, to the extent that we are aware, any (1) unauthorized access to our information technology systems that either occurred or is reasonably likely to have occurred, including of reports submitted to us by third parties (including regulatory agencies, law enforcement agencies and security consultants), to the extent that such unauthorized access to our information technology systems is reasonably likely to have a material effect on the financial statements, in each case or in the aggregate, and (2) ransomware attacks when we paid or are contemplating paying a ransom, regardless of the amount.

D. Liabilities and Contingencies

1. All liabilities and contingencies, including those associated with guarantees, whether written or oral, have been disclosed to you and are appropriately reflected in the financial statements.
2. We have informed you of all outstanding and possible litigation and claims, whether or not they have been discussed with legal counsel.
3. We have recorded and/or disclosed, as appropriate, all liabilities related to litigation and claims, both actual and contingent, and have disclosed in "Contingent liabilities and commitments" notes to the financial statements all guarantees that we have given to third parties.

E. Ownership of Assets

++

1. Except for assets recognized as right-of use assets in accordance with IFRS 16 *Leases*, the Group and the Company has satisfactory title to all assets appearing in the balance sheet, and there are no liens or encumbrances on the Group and the Company's assets, nor has any asset been pledged as collateral, other than those that are disclosed in Notes to the financial statements. All assets to which the Group and the Company has satisfactory title appear in the balance sheet.
2. All agreements and options to buy back assets previously sold have been properly recorded and adequately disclosed in the financial statements.
3. There are no formal or informal compensating balance arrangements with any of our cash and investment accounts. Except as disclosed in "Contingent liabilities and commitments" note to the financial statements, we have no other line of credit arrangements.

F. Equity

1. We have properly recorded or disclosed in the financial statements the share/capital stock repurchase options and agreements, and shares/capital stock reserved for options, warrants, conversions and other requirements

G. Contingent Liabilities

1. We are unaware of any violations or possible violations of laws or regulations the effects of which should be considered for disclosure in the financial statements or as the basis of recording a contingent loss other than those disclosed or accrued in the financial statements.
2. We are unaware of any known or probable instances of non-compliance with the requirements of regulatory or governmental authorities, including their financial reporting requirements, and there have been no communications from regulatory agencies or government representatives concerning investigations or allegations of non-compliance, except as follows:

Matters of routine, normal, recurring nature (e.g., examinations by FRC and examinations by taxing authorities) none of which involves any allegations of noncompliance with laws or regulations that should be considered for disclosure in the financial statements or as a basis for recording a loss contingency.

H. Capital Commitments and Off- Balance Sheet Items

1. At the year end, the Group and the Company had no unusual commitments or contractual obligations of any sort which were not in the ordinary course of business and which might have an adverse effect on the financial statements (e.g., contracts or purchase agreements above market price; repurchase or other agreements not in the ordinary course of business; material commitments for the purchase of property, plant and equipment; significant foreign exchange commitments and open balances on letters of credit, etc).
2. There were no material commitments for construction or acquisition of property, plant and equipment or to acquire other non-current assets, such as investments or intangibles, other than those disclosed in the financial statements.

I. Income and Indirect Taxes

1. We acknowledge our responsibility for the tax accounting methods adopted by the Group and the Company, which have been consistently applied in the current period, and for the current year income tax provision calculation.
2. We also acknowledge our responsibility for the plans with respect to future taxable income, which represent our estimates as to the outcome of those plans, based on available evidence, and for the significant assumptions used in our analysis. We would implement such strategies as necessary to prevent a tax operating loss or credit carryforward from expiring.
3. We have disclosed to you all tax opinions, correspondence with tax authorities, or other appropriate information that served as support for the accounting for potentially material matters.
4. Adequate amounts have been accrued for all local and foreign taxes on income including amounts applicable to prior periods not finally settled and paid. Deferred income tax has been accounted for with International Financial Reporting Standards.

J. Use of the Work of Specialists

1. We agree with the findings of the specialists that we engaged to evaluate the estimates and have adequately considered the qualifications of the specialists in determining the amounts and disclosures included in the financial statements and the underlying accounting records. We did not give or cause any instructions to be given to the specialists with respect to the values or amounts derived in an attempt to bias their work, and we are not otherwise aware of any matters that have had an effect on the independence or objectivity of the specialists.

K. Estimates

Estimations and significant judgments

1. We confirm that the disclosures made in the financial statements with respect to the accounting estimates, including those describing estimation uncertainty, are complete and are reasonable in the context of IFRSs.
2. We confirm that the significant judgments made in making the *Expected credit loss of financial assets* have taken into account all relevant information of which we are aware.
3. We believe that the selection or application of the methods, assumptions and data used by us in respect of the fair value of the land and buildings have been consistently and appropriately applied or used in making the revaluation.
4. We confirm that the significant assumptions used in pricing of derivative financial instruments appropriately reflect our intent and are the best estimates of the value of derivatives to the extent of our knowledge.
5. We confirm that appropriate specialized skills or expertise has been applied in making the accounting estimate.
6. We confirm that no adjustments are required to the accounting estimates and disclosures in the financial statements.

L. Operating segments

1. We confirm that operating segments have been identified appropriately based on the way in which the segments are organized within the Group and the Company for making operating decisions and assessing performance. Subject to the specific requirements of IFRS 8 *Operating segments*, financial information is disclosed in the same manner and based on the same policies as they are reported internally and used by that person or group of persons (the Group and the Company's chief operating decision maker) that make decisions about the resources to be allocated to the operating segments and assess their performance.

M. Independence

1. We are not aware of any act or omission on the part of the entity that does or may impact on your ability to comply with your independence obligations as auditor of the entity. We have brought to your attention any items which we consider may affect your ability to remain independent of the entity and we will continue to work with you to maintain the independence of the audit relationship.

N. Preparation of summary financial statements

We have fulfilled our responsibility for the preparation of the summary financial statements on the basis described in Note "Basis for preparation" in the summary financial statements and believes such basis is acceptable.

Management has made the audited financial statements readily available to the intended users of the summary financial statements, when the summary financial statements will not be accompanied by the audited financial statements.

O. Comparative information – comparative financial statements

In connection with your audit of the comparative financial statements for the year ended 31 December 2023, we represent, to the best of our knowledge and belief, the following:

1. There have been no significant errors or misstatements, or changes in accounting policies that would require a restatement of the amounts from the financial statements for the year ended 31 December 2023 which are shown as comparative amounts in the financial statements for the year ended 31 December 2024. Any differences in the comparative

amounts from the amounts in the financial statements for the year ended 31 December 2023 which disclosed in "Comparative information" note are solely the result of reclassifications for comparative purposes.

P. Subsequent Events

1. Other than described in "Subsequent events" note to the financial statements, there have been no events subsequent to period end which require adjustment of or disclosure in the financial statements or notes thereto.

Q. Other information

1. We acknowledge our responsibility for the preparation of the other information. The other information comprises Annual Report as of 31 December 2024.
2. We confirm that the content contained within the other information is consistent with the financial statements.
3. We will provide to you the final version of documents when available and prior to issuance by us, such that you can perform your procedures.

Regards,



Ariunzul Gankhuyag

(Head of Financial Reporting Department)



“ИНВЕСКОР ББСБ” ХК
**2024 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Агуулга

1. Онцлох үйл явдал	03
2. Санхүүгийн үр дүн	07
3. Хувьцаа	07
4. Ногдол ашиг	08
5. Зээлийн үйл ажиллагаа	09
6. Төв Азийн үйл ажиллагаа	10
7. Зохистой харьцааны үзүүлэлт	11
8. Эрсдэлийн удирдлага	12
9. Тогтвортой хөгжил	13
10. Хүний нөөцийн онцлох үр дүнгүүд	14
11. Компанийн бүтэц	15
12. Гүйцэтгэх удирдлагын баг	16
13. Компанийн засаглал	17
14. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн	18
15. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2024	19

Онцлох үйл явдал



Казахстан улсад үйл ажиллагаа эхлүүллээ

Инвескор ББСБ ХК нь Төв Ази дахь үйл ажиллагаагаа тэлж Казахстан улсад “Инвескор Финанс” охин компаниа байгуулах албан ёсны нээлтийн үйл ажиллагаа 2024 оны 9-р сарын 14-нд зохион байгууллаа.

Ингэснээр бид Төв Азийн 2 дахь улсад охин компаниа байгуулж, үйл ажиллагаа тэлж буй бөгөөд Монгол санхүүгийн байгууллага олон улсад зах зээлээ тэлж, гаднын хэрэглэгчдэд хүрч үйлчилгээ үзүүлэх боломж бүрдэж байгаа дээр Монгол мэргэжилтнүүд ч Төв Азид ажиллаж, удирдан түүчээлэх үүд хаалга улам өргөжин тэлсээр байна.



50 тэрбум төгрөгийн ХБҮЦ

"InvesCore ABS" Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 100%-ийн гүйцэтгэлтэй, 50 тэрбум төгрөгийг нэг удаагийн транчаар амжилттай татан төвлөрүүлээ. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлд нэг удаагийн транчаар хамгийн өндөр хөрөнгө татан төвлөрүүлсэн түүхэн амжилт болж байна.

"InvesCore ABS" ТЗК нь нийт 18 сарын хугацаатай, 17 хувийн хүүтэй, 12 болон 18 дахь саруудад үндсэн төлбөрийг тэнцүү хуваан төлж, ахин хөрөнгө оруулалт хийх замаар бодит өгөөжийн түвшнийг нэмэгдүүлэх боломжтойгоор олон нийтэд онцгой нөхцөл санал болгосон билээ.



Олон улсын "А" үнэлгээг дахин баталгаажууллаа.

"Инвескор ББСБ" ХК нь олон улсын "MicroFinanza Rating" SRL байгууллагаас авсан "А" үнэлгээгээ ахин амжилттай баталгаажууллаа.

Үнэлгээг тогтоосон суурь хүчин зүйлүүд нь "Инвескор ББСБ" ХК-ийн олон улсын жишигт нийцсэн компанийн засаглал, стратеги, зээлийн багцын чанар, үйл ажиллагаа, систем, санхүүгийн төлөв байдал зэрэг юм.

"MicroFinanza Rating" SRL нь банк, санхүүгийн байгууллагуудын урт хугацааны тогтвортой байдлын үнэлгээ болон зээлжих зэрэглэлийг тогтоодог дэлхийд тэргүүлэгч агентлаг бөгөөд 110 гаруй улсын 2800-аад байгууллагуудад үнэлгээ хийсэн байна. "А" рейтинг нь Монгол улсын санхүүгийн байгууллагууд дундаа хамгийн өндөр үнэлгээ бөгөөд "Инвескор ББСБ" ХК-ийн гадаад зах зээлээс эх үүсвэр татах болон хөрөнгө оруулагч нартай түншлэлээ идэвхжүүлэх үйл ажиллагаанд томоохон давуу тал болж байна.

Онцлох үйл явдал



ISO 27001, ISO 9001 стандартын баталгаажуулалтыг 3 дахь жилдээ дараалан амжилттай баталгаажууллаа.

“Инвескор ББСБ” ХК ISO/IEC 27001:2022 болон ISO 9001:2015-ийн стандартын шаардлагуудыг 3 дахь жилдээ дараалан амжилттай баталгаажуулсан бөгөөд дэлхий даяар 400 гаруй компанид энэ чиглэлээр аудит хийсэн туршлагатай MSECB байгууллага нь Инвескор Санхүүгийн байгууллагад хийсэн аудитаараа биднийг хамгийн амжилттай, мэргэжлийн түвшинд ажиллаж энэхүү нэгдсэн тогтолцоог бий болгож баталгаажуулсан хэмээн тодотгон өөрсдийн Success Story-доо онцлон оруулсан юм.



BlueOrchard MicroFinance 10 сая ам.долларын санхүүжилт татлаа.

“Инвескор ББСБ” ХК нь нийт хөрөнгө оруулалтаар дэлхийн хамгийн томд тооцогдох Хөрөнгө оруулалтын сан болох болох BlueOrchard MicroFinance Fund (BOMF) -аас 10.0 сая ам.долларын санхүүжилт авах гэрээнд гарын үсэг зурлаа.

Гэрээнд гарын үсэг зурах ёслол Инвескор Санхүүгийн Байгууллагын төв байранд зохион байгуулагдаж, хоёр талаас гэрээг үзэглэснээр хоёр байгууллагын хамтын ажиллагаа албан ёсоор эхэллээ.



Ногоон санхүүжилтийн бүтээгдэхүүн нэвтрүүлэв.

“Инвескор ББСБ” ХК нь Ногоон зээлийн санхүүжилтээр дамжуулан байгальд ээлтэй төслүүдэд хөрөнгө оруулж, эрчим хүчний хэмнэлт, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, байгаль орчны бохирдлыг багасгах зорилгоор ногоон зээлийн бүтээгдэхүүнийг нэвтрүүллээ.

Ногоон зээлийн санхүүжилтийг олгосноор бизнесүүд үйл ажиллагаандаа ногоон технологи нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаанд шилжихэд дэмжлэг болох бөгөөд энэхүү бүтээгдэхүүн нь бидний тогтвортой хөгжилд үзүүлэх чухал түлхэц болно.

Онцлох үйл явдал



Global Gender Smart сангаас бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор 4.5 сая ам.долларын санхүүжилт татлаа.

“Инвескор ББСБ” ХК нь байгаль орчин, нийгэм болоод жендерийн эрх тэгш байдлыг эрхэмлэн жижиг дунд бизнес эрхлэгч нарт хүртээмжтэй санхүүжилт олгосоор ирсэн билээ.

Энэ удаад бид Глобал Жендер-Смарт Сантай (GGSF) хамтран жижиг дунд бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор 4.5 сая ам.долларын санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурсныг дуулгахад таатай байна.



Банк Бус Санхүүгийн Байгууллагын "Энтерпренер 2024" шагналыг хүртлээ.

“Инвескор ББСБ” ХК нь 2024 ондоо дотоодын зах зээлд өрсөлдөхөөс илүү үндэстэн дамнаж гадаадын зах зээлд Монгол компани тэр дундаа Монгол хүн дэлхийд хангалттай өрсөлдөж чадна гэдгийг харуулсныг үнэлж Банк Бус Санхүүгийн Байгууллагын "Энтерпренер 2024" шагналыг хүртлээ.

Энэ бол харилцагч, хөрөнгө оруулагч болоод хамтран ажиллагч байгууллага бидний хамтын амжилт юм.



Rio Tinto & InvesCore –ийн нөлөөллийн санхүүжилт

“Инвескор ББСБ” ХК болон Rio Tinto-тай хамтран хэрэгжүүлсэн “Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хаалтын үйл ажиллагаа амжилттай болж өндөрлөлөө.

Бид Рио Тинто Монгол ХХК-тай хамтран 3 жилийн турш амжилттай хэрэгжүүлсэн Жижиг, дунд бизнесийг дэмжих хөтөлбөрийн хаалтын арга хэмжээг бизнес эрхлэгчидтэйгээ хамтдаа хийлээ.


2021 онд COVID-19 цар тахлын үед ЖДҮ эрхлэгчид санхүүгийн бэрхшээлтэй тулгарч байсан хүнд цаг үед эхлүүлсэн энэхүү санаачилга нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чухал дэмжлэг үзүүлэх зорилготой байлаа. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд бид 183 бизнес эрхлэгчдэд 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгож, тэдний бизнесийг өргөжүүлэх, хөгжүүлэх боломжийг олгосон.

Онцлох үйл явдал



Төв Азид “Монгол” экспатууд ажиллаж байна.

Инвескор ББСБ-ын Төв Азид байрлах Киргизстан, Казакстан дахь охин компаниудад Монгол экспатууд томилогдон, толгой компанийн стратеги, бодлогыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бизнесийн үйл ажиллагааг оновчтой удирдан, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна.



Роскет итгэлцлийн үйлчилгээг нэвтрүүлээ.

Санхүүгийн Зохицуулах Хорооны итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүрээнд 2024 оны 5 сард хэрэглэгчдэдээ зориулан санхүүгийн сахилга баттай байж, хуримтлал үүсгэх “Ирээдүйгээ бүтээ” уриатай цахим итгэлцлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн.

Үүнд 4 төрлийн итгэлцлийн туслах бүтээгдэхүүн нэвтрүүлэв.

- Хүүхдийн итгэлцэл
- Аяллын итгэлцэл
- Автомашины итгэлцэл
- Энгийн итгэлцэл




Роскет ТОС холбоонд нэгдэж, 2 дахь жилдээ БОНЗ тайлан гаргалаа

Инвескор хэтэвч ББСБ ХХК нь Монголын Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТОС Холбоо)-ны 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн Удирдах зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу ТоС холбоонд ҮНДСЭН гишүүнээр элсэж орж, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллахаар боллоо.

Санхүүгийн үр дүн (нэгтгэсэн)

*аудитлагдсан


Нийт актив (тэрбум төгрөг)




Зээлийн багц (тэрбум төгрөг)




Хүү, шимтгэлийн орлого (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг (тэрбум төгрөг)



Хувьцаа



Хаалтын ханш: 8735 ₮

Зах зээлийн үнэлгээ: 662 тэрбум ₮

2024 оны ханшийн өсөлт: 25%

2024 оны арилжаа: 35.6 тэрбум ₮


Гаргасан хувьцаа: 75,744,281

Ногдол ашиг

ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 10-ны өдрийн №09 тогтоолын дагуу:

- Нэгж энгийн хувьцаанд 60 ₮ буюу нийт 4,554,656,860 төгрөгийн ногдол ашгийг тараана
- Бүртгэлийн өдөр: 2025/04/07
- 2024 оны цэвэр ашгийн 5.4%
- Ногдол ашиг тараах өдөр: 2025/04/23

Хуваарилсан ногдол ашгийн дүн (сая төгрөг)




НОГДОЛ АШИГ ХУВААРИЛНА.

Нийт дүн: **4,544,656,860 ₮**

Нэгж хувьцаанд: **60 ₮** ▲13%

Ногдол ашгийг 2025 оны 04 дугаар сарын 23-ны өдөр Компанийн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар боллоо.

Зээлийн үйл ажиллагаа



2024 ҮЕ	Хугацаа хэтэрсэн зээл хувь	Чанаргүй зээлийн хувь
Банк	3.5%	5.1%
ББСБ	3.1%	6.1%
Инвескор	3.5%	5.5%

- Нийт зээлийн багц 51% өсч 733 тэрбумд хүрлээ.
- Жижиг дунд бизнесийг дэмжиж ажилласнаар уламжлалт зээлийн багцын 60 орчим хувийг бизнесийн зээл эзэлж байна.

Төв Азийн үйл ажиллагаа

Төв Ази дахь нийт зээлийн багц **60 тэрбум ₮**
Нийт салбарын тоо **6**



Инвескор Си Эй МФК (Киргиз улс)

2024 онд 2 удаа бонд гаргах замаар 7 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц гадаад эх үүсвэрийг Киргиз улсын зах зээлээс амжилттай татан төвлөрүүллээ.

Инвескор Си Эй МФК нь Киргиз улсын бичил санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлж Киргиз улсын ББСБ-уудын TOP 6 дугаар байрт жагсаж байна.



Инвескор Финанс МФО (Казахстан улс)

Казахстан улс дахь охин компани болох Инвескор Финанс нь зохицуулагч байгууллагаас үйл ажиллагаа эхлүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг амжилттай хангаж 2024 оны 6 дугаар сарын 18-нд тусгай зөвшөөрлөө авсан бөгөөд нээлтийн үйл ажиллагааг 2024 оны 9 дүгээр сарын 16-нд амжилттай зохион байгуулсан.



Зохистой харьцааны үзүүлэлт

*Инвескор ББСБ ХК тусдаа

Шалгуур үзүүлэлт	Байвал зохих	Тайлангаар	Хангасан эсэх
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт			
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	25.8%	Хангасан
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	28.0%	Хангасан
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-аас доошгүй	23.3%	Хангасан
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас доошгүй	29.4%	Хангасан
Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт			
Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас доошгүй	8.5%	Хангасан
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	25%-аас доошгүй	15.5%	Хангасан
ББСБ-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	10%-аас доошгүй	8.5%	Хангасан
Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-аас доошгүй	20.0%	Хангасан
Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас доошгүй	10.5%	Хангасан
Монголын хөрөнгийн биржийн "i", "ii" ангилалын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	20%-аас доошгүй	2.3%	Хангасан
Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас доошгүй	9.5%	Хангасан
Гадаад валютын ханшийн эрсдэл			
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-8.8%	Хангасан
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд			
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	100%-аас хэтрэхгүй	92.1%	Хангасан
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	23.8%	Хангасан
Үндсэн хөрөнгийн үзүүлэлт			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.2%	Хангасан

Эрсдэлийн удирдлага

“Инвескор ББСБ” ХК-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны гол зорилго нь эрсдэлийн төрөл тус бүрээр хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлох, түүний хүрээнд эрсдэлийг үр дүнтэй, үр ашигтай удирдахад чиглэгддэг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд бизнесийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний хүрээнд эрсдэлийг үр дүнтэй удирдах хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.

Инвескор ББСБ” ХК нь **Хамгаалалтын 3 бүсийн зарчимд** тулгуурласан эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгон үйл ажиллагаандаа идэвхтэй хэрэгжүүлж ажилладаг ба тус зарчмын дагуу хамгаалалтын бүс тус бүр эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоонд тодорхой чиг үүргийг гүйцэтгэдэг.

Эрсдэлийн удирдлага

Хамгаалалтын гурван бүс

Эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүргийг тодорхойлох өдөр тутмын эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа

Засаглалын бичиг баримтууд

Эрсдэлийн удирдлагын бодлого, холбогдох эрсдэлүүдийг удирдах бодлого, журмууд болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журам, стандарт болон заавар

Засаглалын хороод

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээний удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих хороод.

Компани жил бүр дотоод үйл ажиллагаандаа мөрдөж буй эрх зүйн баримт бичгүүд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр тусгаж, хэрэгжүүлж байгаа эсэхэд **Хуулийн нийцлийн үнэлгээ** гүйцэтгэж, хуулийн нийцлийг хангуулах, хуулийн зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулдаг.


Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитын чиг үүрэг нь Компанийн үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор хараат бус, бодитой баталгаажуулалт хийх, мөн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг.

Компанийн засаглалын кодекс болон Дотоод аудитын институт (The IIA)-ээс боловсруулсан “Хамгаалалтын 3 бүс”-ийн зарчмын дагуу Гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар үйл ажиллагаагаа зохион байгуулж, ТУЗ-ийн дэргэдэх “Аудитын хороо”-нд шууд тайлагнан ажилладаг.

2024 оны I хагас жилийн төлөвлөгөөг 100 хувиар, харин II хагас жилийн төлөвлөгөөг 125 хувиар тус тус гүйцэтгэсэн. Тухайлбал, 2024 онд үйл ажиллагааны иж бүрэн 4 аудит, хэсэгчилсэн 7 аудитыг гүйцэтгэж тайлагнасан байна.

Инвескор ББСБ ХК-ийн Дотоод аудит нь бүтэц зохион байгуулалтын хувьд үндсэн үйл ажиллагааны аудит болон мэдээлэл технологийн аудит гэсэн 2 үндсэн чиглэлээр зохион байгуулагдан ажилладаг.



Тогтвортой хөгжил



Ногоон санхүүжилт

Инвескор ББСБ нь байгаль орчин, нийгэмд эерэг өөрчлөлт үзүүлэх зорилгоор ногоон зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна.

Бид байгальд ээлтэй хөрөнгө оруулалтыг дэмжиж, тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэхийн тулд ногоон зээлийг төрөлжүүлэн санал болгож, хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Ногоон зээлийн бүтээгдэхүүнүүд:

- Бизнесийн ногоон зээл
- Автомашины ногоон зээл
- Хэрэглээний ногоон зээл



Тогтвортой эх үүсвэр

Инвескор ББСБ нь BlueOrchard MicroFinance Fund, ResponsAbility, Lendahand зэрэг нь Олон улсын хөгжлийн хөрөнгө оруулалтын байгууллагуудаас бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжихэд зориулагдах тогтвортой эх үүсвэрүүдийг бүрдүүлж чадсан бөгөөд энэ нь нийт эх үүсвэрийн 18%-ыг эзэлж байна.

Энэхүү тогтвортой эх үүсвэрүүдийг ашиглан харилцагчдын санхүүгийн хэрэгцээг хангаж, бизнесийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, тэр дундаа эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих замаар дотоодын эдийн засгийн өсөлтөд эерэг хувь нэмэр оруулах чухал ач холбогдолтой юм.



Жендерийн эрх тэгш байдал

Инвескор ББСБ ХК-ийн Удирдлагын хороо нь компанийн бизнесийн гол шийдвэрүүдийг гаргах чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тус хороо нь жендерийн эрх тэгш байдал, хүйсийн тэнцвэртэй байдлыг хангасан бүрэлдэхүүнтэй болно.

Мөн Удирдлагын багийн гишүүд болон салбарын ажилтнууд Азийн Хөгжлийн Банкны "Жендерийн эрх тэгш байдал"-ын сургалтад хамрагдаж, олон улсын туршлага, жендерийн мэдрэмжтэй удирдлагын арга барилыг судалсан.

Хүний нөөцийн онцлох үр дүнгүүд



Ажилтнуудын тоо

+31 шинэ орон тоо – Өмнөх оны төгсгөлтэй харьцуулахад үндсэн ажилтны тоогоо 17%-р өсгөж 214 ажилтантай болов. Мөн салбарт бүтэн бус цагаар ажиллах 12 орон тоог бий болгов.

Эмэгтэй удирдлагууд: Гүйцэтгэх удирдлагын багт эмэгтэй захирлуудын эзлэх хувийг нэмэгдүүлж, хүйсийн харьцаа тэнцвэртэй болов.



Дотоод шилжилт, карьер хөгжил

35 ажилтан компани дотроо албан тушаал ахисан байна (+75%).

Сургалт хөгжил: Сургалт хөгжлийн төсвөө 102%-р нэмэгдүүлж, давхардсан тоогоор 690 ажилтныг 986 цагийн сургалтад хамруулав.

Нэг хүнд ногдох сургалтын дундаж цаг: 8.7 цаг.



Суралцах соёл

Talent LMS сургалтын платформыг нэвтрүүлж, тасралтгүй суралцах соёлыг бүрдүүлэв. Карьер хөгжил, бие биеэсээ суралцах соёлыг дэмжих зорилгоор 6 сарын хугацаатай **'Mentormind24' хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэв**. Компани дотроо өөрийн түүх, туршлага, ажлын арга барилаа хуваалцах боломжийг бүрдүүлж **'One of us' подкастыг хийж эхлүүлэв**.



Ажил олгогчийн брэнд

Ажил олгогчийн брэнд, компанийн үнэ цэнээ нээлттэй танилцуулахаар 'InvesCore Journey' Facebook хуудсыг эхлүүлэв.



Ажилтны эрүүл мэнд

Ажилтнуудынхаа эрүүл мэндэд онцгой анхаарч, ажилтан бүрийг хувийн эрүүл мэндийн даатгалд хамруулж, Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 100% хамруулаа.




Ажилтнуудын дуу хоолой

Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр нийт ажилтнуудыг хамруулан зохион байгуулдаг бөгөөд сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн байгууллагын соёл болон хүний нөөцийн үйл ажиллагаа зохион байгуулж байна.

Ажилтнуудынхаа дуу хоолой, санал хүсэлтийг хүлээн авах сувгаа нээлттэй ажиллуулж, ажилтнуудын хүсэлтийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Компанийн бүтэц



Гүйцэтгэх удирдлагын баг



Д.Баясгалан

Гүйцэтгэх захирал



Ц.Алтаннавч

Үйл ажиллагаа
хариуцсан захирал



З.Батцэцэг

Хүний нөөц
хариуцсан захирал



Ш.Оюунчимэг

Бизнес хариуцсан захирал



О.Төгөлдөр

Цахим шилжилт
хариуцсан захирал



С.Тулга

Хөрөнгө оруулалт
хариуцсан захирал

Охин компаниудын удирдлага



Д.Оролмаа

Инвестор Хэтэвч ББСБ ХХК
Гүйцэтгэх захирал



Серик С. Жанаев

Инвестор Финанс МФО
Гүйцэтгэх захирал

Казахстан улс



Кунболот Азатбек уулу

Инвестор СА МФС
Гүйцэтгэх захирал

Киргиз улс


Компанийн засаглал

Инвекор ББСБ нь компанийн засаглалыг ил тод, хариуцлагатай, олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжүүлэхийг эрхэмлэдэг. Хараат бус болон гүйцэтгэх удирдлагын төлөөллийг тэнцвэртэй оролцуулсан Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-тэй бөгөөд хяналт, эрсдэлийн удирдлага, ёс зүй, ил тод байдлыг хангах бодлого, журмуудыг тогтмол сайжруулж, хэрэгжүүлдэг. Мөн компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын тулд хувь нийлүүлэгчид, харилцагчид, ажилтнууд болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалахыг зорьж ажилладаг.

Инвекор ББСБ-ийн хувьцаа эзэмшлийн бүтэц

Инвекор ББСБ нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй, хувьцаагаа олон нийтэд нээлттэй арилжаалдаг компани бөгөөд хувьцаа эзэмшлийн бүтэц нь ил тод, зохистой удирдлагатай байна. Компанийн хувьцаа эзэмшигчид нь дотоодын болон олон улсын хөрөнгө оруулагчид, стратегийн болон жижиг хувьцаа эзэмшигчдээс бүрддэг.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



ТУЗ-ийн бүрэлдэхүүн



Б.Анхболд
ТУЗ-ийн дарга



Д.Баясгалан
ТУЗ-ийн гишүүн



Хирохито Намики
ТУЗ-ийн гишүүн



Т.Тэлмэн
ТУЗ-ийн гишүүн



Р.Пүрэв
ТУЗ-ийн гишүүн



Ч.Хашчулуун
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Д.Энхбат
ТУЗ-ийн хараат
бус гишүүн



Ч.Өнөржаргал
ТУЗ-ийн хараат
бус гишүүн

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод



Хороодын гишүүд /ТУЗ-ийн дэргэдэх хороод/

• Аудитын хороо	Дарга: Ч.Хашчулуун	Гишүүд: Ч.Өнөржаргал, Р.Пүрэв
• Нэр дэвшүүлэх хороо	Дарга: Ч.Хашчулуун	Гишүүд: Д.Энхбат, Х.Намики
• Цалин урамшууллын хороо	Дарга: Д.Энхбат	Гишүүд: Т.Тэлмэн, Ч.Өнөржаргал
• Эрсдэлийн удирдлагын хороо	Дарга: Ч.Өнөржаргал	Гишүүд: Б.Анхболд, Ч.Хашчулуун
• Тогтвортой байдлын хороо	Дарга: Ч.Хашчулуун	Гишүүд: Д. Баясгалан, Б.Анхболд

ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

	Бүрэлдэхүүн	Хуралдсан байдал	Чиглэл
ТУЗ	Хурлын дарга: Б.Анхболд • Хараат бус гишүүн: 3 • Ердийн гишүүн: 4	Нийт 36 удаа хурал • Эчнээ хурал: 26 • Цахим хурал: 8 • Биет хурал: 2	- Бизнес төлөвлөгөө, төсөв батлах - Үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, удирдлагын багийн гүйцэтгэл - Гадаад болон ОУ-ын эх үүсвэр - Сонирхлын зөрчилтэй хэлцэл
Аудитын хороо	Хурлын дарга: Ч.Хашчулуун • Гишүүн: Ч.Өнөржаргал • Гишүүн: Р.Пүрэв	Нийт 16 удаа хурал • Эчнээ хурал: 5 • Цахим хурал: 10 • Биет хурал: 1	- Дотоод хяналт, дотоод аудит - Хөндлөнгийн аудит сонгох, хяналт тавих - Сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах
Эрсдэлийн удирдлагын хороо	Хурлын дарга: Ч.Өнөржаргал • Гишүүн: Ч.Хашчулуун • Гишүүн: Б.Анхболд	Нийт 8 удаа хурал • Эчнээ хурал: 2 • Цахим хурал: 6	- Эрсдэлийн бодлого, аппетит - Эрсдэлийн тайлан - ТУЗ-өөс олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээл шийдвэрлэх
Тогтвортой байдлын хороо	Хурлын дарга: Ч.Хашчулуун • Гишүүн: Д.Баясгалан • Гишүүн: Б.Анхболд	Нийт 3 удаа хурал • Биет хурал: 1 • Цахим хурал: 2	- БОНЗ тайлан - Ногоон санхүүжилтийн бодлого - БОНЗ чиглэлээрх хөрөнгө оруулалт
Цалин урамшууллын хороо	Хурлын дарга: Д.Энхбат • Гишүүн: Т.Тэлмэн • Гишүүн: Ч.Өнөржаргал	Нийт 1 удаа хурал • Цахим хурал: 1	- Удирдлагын багийн цалин урамшуулал - Байгууллагын цалингийн бодлого, систем

Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуур

Бизнес төлөвлөгөөнд тусгасан Тэнцвэржүүлсэн онооны систем дэх зорилтуудын биелэлтээр Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин болон бусад урамшууллыг олгодог.

Үүнд доорх 4 үндсэн бүлэг үзүүлэлтүүдийг багтаана.

- Санхүүгийн тоон зорилтуудын биелэлт
- Зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагчийн үйлчилгээний зорилтуудын биелэлт
- Дотоод процессын сайжруулалт, бизнес хөгжлийн үйл ажиллагааны зорилтуудын биелэлт
- Хүний нөөц, бүтээмжтэй холбоотой зорилтуудын биелэлт

InvesCore FI

+976 7709-0077

info@invescore.mn

www.invescore.mn